



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/22

Жавхланта

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дахь тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялагч, амрагч иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор моторт завь худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхзаяа Засаг даргын Орлогч

Гишүүдэд: П.Цолмонбаяр Улсын бүртгэгч

Нарийн бичгийн дарга: Ш.Эрдэнэзаяа Байгаль орчны улсын байцаагч

2. Худалдан авах үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Энхзаяа), нарийн бичгийн дарга (Ш.Эрдэнэзаяа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР